

СЭДЭВ: ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛТИЙГ АШИГЛАХ НЬ

USING THE ADVANCES OF MODERN TECHNOLOGY IN IMPROVING THE MONITORING OF EX-CONVICTS



Д.ЦЭНД-АЮУШ

Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн мэдээлэл судалгааны ахлах мэргэжилтэн, Хууль сахиулахын их сургуулийн магистрант, цагдаагийн ахмад

TSEND-AYUSH D.

(M.L. Student & Police Captain) Senior Specialist at the Second Division for Information and Research of Songinokhairhan District

Товч агуулга: Цагдаагийн байгууллагаас хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавих захиргааны хяналтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хяналт тавих үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх үүднээс орчин үеийн техник технологийг хөгжил дэвшилтийг ашиглах боломж нөхцөлийн талаар санал дүгнэлт дэвшүүлэх оролдлого хийлээ.

Abstract: The author of this paper has attempted to propose the possibilities of using modern technology in improving the monitoring of ex-convicts after conducting analysis on the current situation and practices of overseeing former prisoners after their release.

Түлхүүр үг: Захиргааны хяналт цахим программ.

Keyword: administrative control program

Захиргааны хяналт нь тухайн байгууллагын өдөр тутмын шуурхай ажилд шууд оролцохгүйгээр хууль, эрх зүйн актыг хэрхэн биелүүлж байгаатай танилцан шалгаж, эрх зүйн зөрчлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, хууль ёсны тодорхой шаардлага тавих замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэгдсэн идэвхтэй ажиллагаа юм.¹

Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд захиргааны хяналт чухал байр суурь эзэлнэ. Энэ нь цагдаагийн байгууллагад тодорхой асуудлаар үүрэг болгосон хууль тогтоомжийг иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс хэрхэн сахин биелүүлж байгаад тавих хяналтын үйл ажиллагаа юм.

Захиргааны хяналтын гол зорилго нь:

- Бүх нийтээр дагаж мөрдөх захиргааны журмыг амьдралд хэлбэрэлтгүй сахин биелүүлэх явдлыг хангах
 - Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох
- Эрх зүйн зөрчил гаргасан гэм буруутай этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд оршдог.

Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлэх захиргааны хяналт нь бүхэлдээ захиргааны хууль тогтоомж, түүнд нийцэж гарсан захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг. Үүнд: "Монгол Улсын цагдаагийн албаны тухай"², "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай", "Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" зэрэг хуулиудын холбогдох заалт, тэдгээрт нийцэж гарсан эрх зүйн актыг нарийвчлан судалж хяналт тавина.

Сүүлийн үеийн техник технологийг нэвтрүүлж байгаа нь хэсгийн байцаагчид ихээхэн тус болно гэж бодож байна. Энэ мэтийн тулгамдсан асуудал хэдэн арваараа байна. Хэсгийн байцаагчдын дунд илтгэл хэлэлцүүлгийн олонх нь ажлын байрны ачаалал их, өргөн нутаг дэвсгэр хариуцдаг, ажлын байрны стресс, техник технологи дутмаг байдаг зэрэг олон тулгамдсан асуудал практикт тулгарч байна.

Судлаачийн зүгээс үзэхэд 2003 онд Хууль зүй дотоод хэргийн сайдын №2 дугаар тушаалаар батлагдсан "Хорих ял нь шүүхийн шийтгэх тогтоолоор хойшлогдсон ялтны засрал хүмүүжилд хяналт тавих журам"-ын хэрэгжилт сул байгаатай

¹ Ж.Долгорсүрэн, Г.Буянхишиг. "Монгол Улсын захиргааны эрх зүй" УБ., 2008. 224 дэх тал

² "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 1993. №8, 1996. №7, 1996. №8, 1998. №1, 2002. №8.



ХҮҮЛЬ
САХИУЛАХУЙ

холбоотойгоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зөвхөн цагдаагийн эсвэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дангаар хийхээр оруулах нь үр дүнгүй юм.

Хөтөлбөрт туссан суллагдсан хүнийг хөдөлмөр эрхлэхэд зуучлах, нийгмийн амьдралд ороход нь дэмжлэг үзүүлж, байнгын холбоотой ажиллах гэсэн заалтууд нь хэрэгжихэд бэрхшээл учирч болох талтай.

Орчин цагт гэмт хэрэг, гэмт хэрэгтэнтэй тэмцэхэд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлж ашиглах нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Гадаадын улс орнуудад гэмт хэрэгтнүүдийг мөрдөх, тэдний үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх нотлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход уламжлалт аргаас гадна шинжлэх ухаан, технологийн аргуудыг өргөнөөр ашиглаж эхэлсэн нь үр дүнтэй байна³.

Хууль сахиулах байгууллага хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүн амын төвлөрөл, барилгажилт, хот төлөвлөлт, хотын амьдралын хэв маяг, нийгмийн ёс суртахууны доройтол, хотжилтыг даган эрчимжиж буй гэмт явдлын чиг хандлага, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөл зэргийг харьцуулан судалж цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээ онолын болон практикийн түвшинд тодорхойлж, ажиллах шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хүчирхийллийн гэмт хэргийн гаралт нийгэм улс төр, эдийн засаг, ажилгүйдэл, ядуурал зэрэг нөхцөл байдлаас шалтгаалж байгаа ч нийслэл хотод шилжин суурьших хөдөлгөөн нэмэгдэж хүн амын нягтрал их байгаатай холбоотойгоор гэмт хэргийн гаралт нэмэгдсээр байна. Тухайлбал: Бусдын эд хөрөнгийг хулгайлах, дээрэмдэх, танхайрах, иргэдийн амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүд тэр дундаа гэр бүл дэх хүчирхийллийн гэмт хэрэг өссөн ба цаашид ч өсөх хандлагатай байна.

Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд цагдаагийн албаны үйл ажиллагаа, удирдлагын үндсэн зарчмыг шинээр хуульчилсан ба уг зүйлийн 4.1-д Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа "Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн

³ Цагдаа судлал сэтгүүл. 2013. №3. 47 дахь тал.

өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална⁴" гэж заасан нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг сайжруулах эрх зүйн үндсийг зааж өгсөн байна.

Мөн хуулийн 21-р зүйлд Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий 5-7 иргэний төлөөллөөс бүрдсэн орон тооны бус Иргэний зөвлөл аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байна. 21.6.2-д Иргэний хяналтын зөвлөл нь цагдаагийн алба хаагчийн сургалт, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй гэж тусгасан нь шинэчлэн найруулсан цагдаагийн албаны хуулийн 4-р зүйлд заасан зарчмыг хэрэгжилтийг хангаад зогсохгүй цагдаагийн байгууллагаас хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж ашиглах чухал ач холбогдолтой заалт болсон гэж бид үзэж байна.

Гэмт хэргийн гаралтыг хүн амын өсөлттэй холбон авч үзвэл:

Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоор суурин хүн амыг Монгол Улсын нутаг дэвсгэрт болон гадаадад тоологдсон гэж нарийвчилж авч үзэх боломжтой болсноороо өмнөх тооллогоос ихээхэн онцлогтой болжээ. Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаа болон албан ёсны бүртгэлтэй 2647.6 мянга, гадаадад улсад оршин сууж байгаа 107.1 мянган хүн тоологдож, суурин хүн ам 2754.7 мянга болжээ.

Монгол Улсын хүн ам 2000-2010 оны хоорондох 11 жилийн хугацаанд 16.1 хувиар өсөж, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь болсон байна. Өсөлтийн энэ хувь өмнөх тооллого хоорондынхоос 0.1 пунктээр илүү болсон нь хүн амын ердийн хөдөлгөөний цэвэр өсөлт сүүлийн арван жилд илүү байсан, 1990-ээд оны эхний хагаст гадаадад олон арван мянган хүн шилжин суурьшсан шиг томоохон хөдөлгөөн гараагүйтэй холбоотой⁵. Хүн амын өсөлт энэ хэвээр үргэлжилбэл Монголчууд бид 2040 гэхэд 4

⁴ Шинэчлэн найруулсан Цагдаагийн албаны тухай хууль. /legalinfo.mn/

⁵ Хүн ам орон сууцны тооллогын материал. 2010.

сая болох судалгаа гарчээ.

Монгол Улсын хүн ам өсөж хотжих үйл явц эрчимтэй явагдаж байгаа цаг үеэ дагаад гэмт хэргийн гаралт нэмэгдэж байна.


Дээрх тоон үзүүлэлтүүдээс үзэхэд гэмт хэргийн гаралт арван жил тутамд тогтвортой өсөж байгаа нь харагдаж байна. Энэ нь хүн амын өсөлт болон нийгэм, улс төр, эдийн засгийн зэрэг бусад нөхцөл байдлаас шалтгаалж байгаа ч цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагаанаас ихээхэн хамааралтай.

ХЗДХЯ, ШШГЕГ, ЦЕГ, ГХУСЗЗ-ийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэхийг судлаачийн хувьд анзаарч, энэ чиглэлээр дорвитой ажил, санал, санаачилга гарах цаг болсон гэж үзэж байна.

Өнөөдөр практик дээр оновчтой үр дүнд хүрэхүйц ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэх, албан тушаалтан томилж ажиллуулах шаардлага бий болоод байна. Тухайн хяналтад байгаа хүний оршин байгаа хороо нутаг дэвсгэр дээр дэлгэрэнгүй анкетыг тусгасан мэдээллийг цахим программд байршуулан хяналт тавих, үйл ажиллагаанд ашиглах, энэ программыг хийхэд зориулагдсан төсөв мөнгийг ХЗДХЯ-ны дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл тооцон гаргаж ажиллах шаардлага байна.

Тухайлбал “Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтсийн хариуцсан 9 хорооны захиргааны хяналтад байгаа хүн болон хэсгийн байцаагчийн объект, субъектийн судалгааг дэлгэрэнгүйгээр цахим программд тусган үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Ойролцоогоор цахим программд оруулах мэдээллийн хэмжээ хязгаараас хамааран нэг хэлтэст 10-15 сая төгрөгийн зардал тооцоологдож байна.

Зураг 1. Захиргааны хяналтад байгаа хүмүүсийн харагдах байдал байдал.



Учир нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс

зохион байгуулж ажлууд нийтийг хамарсан өргөн хүрээнд явагдаж байгаагаас биш нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд хангалттай хэмжээнд явагдахгүй байгаа нь харагдаж байна.

Тэгвэл Монгол Улсын туслах тоо бүртгэлийн сан “Цагдаагийн байгууллагаас захиргааны хяналтад байгаа этгээд” гэсэн цахим сангийн мэдээллийн өгөгдлийг сайжруулах, хяналтад байгаа иргэдийг зургийг байршуулах гэх мэт.. мөн цагдаагийн урамшуулалт эргүүл, олон нийтийн цагдаагийн ажилтан нар өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болгох, цахим программ ажиллуулах” ажлыг зохион байгуулах нь цагдаагийн байгууллагын захиргааны хяналтын нэг хэсэг болох хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавих хяналт сайжирч, ингэснээр нь захиргааны зөрчил, гэмт хэргийн гаралт буурах, мөн хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналт сайжирч, хэсгийн байцаагчийн ажлын ачаалал багасаж чадна гэж үзэж байна.

Захиргааны хяналтын үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох зорилгоор Улаанбаатар хотын харьяа дүүргүүдийн цагдаагийн 1,2,3 дугаар хэлтсүүдийн цагдаа олон нийттэй харилцах ахлах байцаагч -21, хэсгийн байцаагч -156, хүүхэд гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх байцаагч -14, ажилтай нийт 191 алба хаагчдаас санал асуулгыг авлаа.

- Захиргааны хяналтын үйл ажиллагааг биечлэн хариуцаж хяналт тавьж ажилладаг хэсгийн байцаагч нар ихэнх хувийг оролцуулан санал асуулга явуулж ажиллаа.

- Цагдаагийн байгууллагаас захиргааны хяналтын үйл ажиллагааг бүрэн хяналтдаа авч хэрэгжүүлэн ажиллаж байгаа хэдий ч хяналт тавьж буй иргэн бүртэй нэг бүрчлэн уулзаж ажиллах ажлын цаг хугацаа хангалтгүй гэж санал асуулгад оролцсон алба хаагчдын 78% хариулсан нь байлаа.

- Захиргааны хяналтад ирүүлж байгаа хүмүүсийн тодорхойлолт, шүүгчийн захирамж нь хуульд заасан хугацаанд хяналт тавих алба хаагчдад ирдэггүй хугацаа хоцорч ирдэг болон суллагдсан хүнийг өөрийн биеэр хүлээлгэж өгдөггүйгээс хүндрэл бэрхшээл гарч байна гэж 53.2 хувь нь дүгнэж хариулсан байлаа

- Алба хаагчдад захиргааны хяналтад ирдэг хүмүүсийн дийлэнх нь хулгай, танхай, бусдын эд зүйлийг дээрэмдэх, булаах, хүчиндэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг

зүйлүүдээр гэмт хэрэг үйлдсэн мөн давтан гэмт хэрэг үйлдэж ирдэг гэж 86,0 хувь дүгнэж хэлсэн байна.

- Захиргааны хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр дагаж мөрдөж байгаа журам, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай байна гэж 96% нь хариулсан байна.

- Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн захиргааны хяналтад байгаа этгээдийг бүртгэх цахим сангийн өгөгдлийг сайжруулах, хэсгийн байцаагч бүр хяналтад байгаа этгээдийг сангаас зургаар нь тулгаж харах, гэх мэт үйлдлүүдийг хийх хэрэгцээтэй байна гэж 48% нь хариулсан

Захиргааны хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны харьяалалд шилжүүлэх нь зүйтэй гэж 68% нь хариулсан байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа хууль эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалт, арга барил, техник хэрэгсэл, тоног төхөөмжийн хоцрогдол, доголдолтой холбоотой байж болох юм.

Нөгөө талаар гэмт хэрэг үлдэгдсэний дараа гэмт хэрэгтнээ хайдаг биш, гэмт хэргийг газар дээр нь илрүүлдэг, гэмт хэрэгтэнтэй хөөцөлддөг биш гэмт хэргийг урьдчилан сэргийлж, таслан зогсоож чаддаг хууль сахиулагчид бий болно.


Ачит-10 цахим системийг нэвтрүүлснээр дараах ач холбогдолтой байна.

- Гэмт хэрэгтнээ хайхад үрэгддэг үр ашиггүй цаг хугацаа зардал хэмнэгдэнэ.
- Иргэний амьд явах эрх болон аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажна.
- Гэмт хэргийн гаралт багасаж, олон нийтийн газар гудамж талбайд үйлдэгддэг танхай, дээрэм булаалт гэх мэт бусад гэмт хэрэг эрс багасна.
- Цагдаагийн алба хаагч нарын амрах цаг бага ч болов нэмэгдэнэ.
- Цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөж жинхэнэ утгаараа хяналтыг бий болгож чадна.


• Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой болно.

Цахим программын талаар зургаар тайлбарлан дэлгэрэнгүй танилцуулбал:


Зураг 2. Ачит-10 програмд байгаа мэдээллийн ерөнхий харагдах байдал.




Зураг 3. Ачит-10 программын захиргааны хяналтад байгаа хүний мэдээллийг дэлгэрэнгүй харах байдал.



Зураг 4. Ачит-10 программын хяналтад байгаа хүний гэр бүл, хань хамсаатны талаар дэлгэрэнгүй мэдээлэл.




Зураг 5. Гэмт хэрэг үйлдэгдсэн байршил, объект, субъектийн судалгааг иж бүрнээр нь харах байдал.



МОНГОЛЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

Зураг 6. Хороо хариуцсан хэсгийн ахлагчийн мэдээлэл дэлгэрэнгүй харах байдал.



Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа иргэний урамшуулалт эргүүл, олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг цагдаагийн байгууллагын захиргааны хяналтын нэг хэсэг болох хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавих хяналт сайжруулах зорилгоор хорооны нутаг дэвсгэрт хариуцсан гудамж талбай хэсэгтээ эргүүл хийхдээ, өөрийн гар утас таблет ашиглан хяналтад байгаа хүний талаар цахим программ ажиллуулан мэдээлэлтэй байх, хаяг дээрээ байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллах нь зүйтэй.

Ингэснээр нь хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналт сайжирч, хэсгийн байцаагчийн ажлын ачаалал багасаж чадна гэж үзэж байна.

Сайн дурын урамшуулалт эргүүлийн хариуцсан хорооны гудамж талбайд ажиллах байдал зураглалаар харуулбал: жишээ:


Урамшуулалтай эргүүлийн гэрийн хаяг:	1. ХМК - 6 байрны зүүн хойд үзүүр
Сонгинохайрхан дүүргийн 6 дугаар хороо	2. ХМК - 6 байрны зүүн урд үзүүр ХМК-58-2-11 тоот 3. ХМК - 6 байрны баруун урд үзүүр
Харилцах утасны дугаар: 96060088	4. ХМК - 6 байрны баруун хойд үзүүр 5. ХМК - автобусны буудал орчим зам дагуу

Зураг 7.



Урамшуулалтай эргүүлийн гэрийн хаяг:	1. Нуурын-1 дүгээр гудамжны баруун үзүүр
Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо	2. Нуурын-1 дүгээр гудамжны зүүн хойд үзүүр
Нуурын 1-17 тоот	3. Нуурын-2 дугаар гудамжны баруун үзүүр
Харилцах утасны дугаар: 88132000	4. Нуурын-2 дугаар гудамжны зүүн үзүүр

Зураг 8.



Тэрчлэн үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж аль дүүрэг хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр хороонд эргүүлийн чиглэлийг түлхүү ажиллуулах, хяналтын системийг түлхүү ашиглах зэрэг үйл ажиллагаагаа сайжруулах ач холбогдолтой юм.

ДҮГНЭЛТ

Бодит байдал дээр цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэдэг хэлбэрээс хэтрэхгүй байгаа ба захиргааны хяналтыг хэрэгжүүлж байгаа цагдаагийн ажилтан, хяналтад байгаа хүмүүсээс ч энэ арга хэмжээг төвөгшөөсөн байдалтай хүлээн авах болсон нь хяналтыг хэрэгжүүлж байгаа хэлбэр, түүнээс хүлээгдэж буй үр дүнгийн тухайд шинэлэг арга хэлбэр, зорилго, зорилтыг дэвшүүлэн гаргаж ирэх цаг болсонтой холбоотой гэж үзэж хорих ангиас суллагдсан хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй байх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, тэднийг нийгэмшүүлэх ажлыг төр анхааралдаа аван, бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах цаг нэгэнт болжээ.

Захиргааны хяналтыг хэрэгжүүлэхдээ хяналтад байгаа хүмүүсийн "бэрхшээлтэй асуудал"-ыг аль болох ойлгож, тэднийг нийгэмшүүлэх тэдэнд хяналт тавихад орчин үеийн техник технологийн дэвшилттэй арга хэрэгслийг

ашиглах, арга хэлбэрийг сонгох нь зүйтэй бөгөөд, үүнийгээ хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог өргөтгөж, эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох, хяналтын ажлын үр нөлөөг тодорхой түвшинд дээшлүүлнэ.

САНАЛ

Хорих ял эдлээд суллагдсан зарим хүмүүст тавих захиргааны хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох орчин үеийн техник технологийг хөгжил дэвшилтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж цахимжуулах, программын шинэлэг арга барилыг хяналт тавих үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхэд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн сан “ Захиргааны хяналтад байгаа этгээд”-г практикт хэрэглэгдэхүйцээр ашиглахад зориулагдсан байх сайжруулах хяналтад байгаа хүний зураг байршуулах гэх мэт... улсын хэмжээнд нэгдсэн тоо мэдээ улирлаар гардаг байх.

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар ялтны засрал хүмүүжил, зан байдал, сэтгэл зүйн онцлог, эрүүл мэнд, эзэмшсэн мэргэжил, гэр бүлийн байдал гэх мэт хувь хүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан нэгдсэн санг бий болгож, уг санд цагдаагийн эрх бүхий ажилтан нэвтрэн орж танилцах нөхцөлийг бүрдүүлсэн санг бий болгох.

- Хэсгийн байцаагч нар захиргааны хяналтад байгаа иргэдийн дэлгэрэнгүй судалгааг анкет байдлаар цахим зураглалд байршуулан шинээр программ бий болгон аппликэйшн татах нууцлалын өндөр зэрэгтэй байлгах, цагдаагийн байгууллагын алба хаагч бүр хэрэглэх эрхтэй байхаар гар утас,таблет, зөөврийн компьютерт байршуулан үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллах.



Хууль сахиулахуй